



# Statement Мэдэгдэл

Улаанбаатар хот, 2020 оны 7 дугаар сарын 8

“Бадрах Энержи” ХХК нь Монгол улсын төрийн өмчит Мон-Атом ХХК болон Франц улсын төрийн өмчит Орано группийн хамтарсан компани юм. Тус компани Дорноговь аймгийн нутагт Зөөвч-Овоо, Дулаан-Уул, Өмнөдийн орд талбайг хамарсан гурван ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг.

“Бадрах Энержи” ХХК нь шилдэг туршлага, стандартыг баримталдаг бөгөөд байгаль орчин, эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдлын онцсайн үзүүлэлтүүдээрээ бахархдаг. Тус компани үйл ажиллагаагаа бүрэн ил тод зарчимд нийцүүлэн явуулдаг бөгөөд Монгол улсын төр, захиргааны байгууллага, орон нутаг болон иргэний нийгмийн төлөөллүүдтэй ойр хамтран ажиллаж ирлээ.

2020 оны 7 дугаар сарын 2-ны өдөр “Бадрах Энержи” компанийн үйл ажиллагааны талаар нийгэмд буруу ташаа ойлголт төрүүлэхүйц мэдээлэл зарим нэг сайт болон олон нийтийн сүлжээгээр цацагдсанд бид харамсаж байна.

Үг хэлэх эрх чөлөө бүхий нээлттэй нийгмийн нэгэн хариуцлагатай оролцогчийн хувьд “Бадрах Энержи” компани үнэн бодит мэдээллийг олон нийтэд хүргэх эрхээ хэрэгжүүлэн хийж буй энэхүү хариуны дэлгэрэнгүйг дараах холбоосоор орж үзнэ үү.  
<https://www.facebook.com/watch/?v=1653395504818514>

Зарим нэг түрэмгий төрийн бус байгууллагын зүгээс сүүлийн жилүүдэд удаа дараа хийж байгаа заналхийлэл, айлган сүрдүүлэлт, далд явуулгыг даван туулж, Монгол улсын бүх хууль, журмын дагуу тус улсад уул уурхайн шинэ салбарыг хариуцлагатайгаар хөгжүүлэхийн төлөө хүсэл эрмэлзэлтэй байх болно.

Бадрах Энержи ХХК  
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
1-р хороо, Жамьян гүний гудамж-9,  
ИСС цамхаг, 3-р давхар

Утас: +976- 70110475 (103)  
<http://www.badrakhenergy.com/MNG/>  
<https://www.facebook.com/badrakhenergy/>